



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/211

Алтай хот

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.30 дахь хэсэг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Жаргалан сумын нутаг Хужирт нэртэй газрын 274.52 га талбайд Ашигт малтмал газрын тосны газраас давхцалгүй гэсэн дүгнэлт ирүүлсэн тул "Хабун мандал" ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосугай.
- 2.Хайгуул хийх газар нутаг, талбайн нэр, талбайн хэмжээ, солбицол, хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралтаар баталсугай.
- 3.Хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулан, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч "Хабун мандал" ХХК (Н.Нямдорж)-д үүрэг болгосугай.
- 4.Хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон зураг зүйн бүртгэлд бүртгэж, хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (С.Амгалан), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас), Жаргалан сумын Засаг дарга (П.Авирмэд)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дугаар сарын 17-ны өдрийн 211 дугаар
захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ХАЙГУУЛ ХИЙХ ГАЗАР НУТАГ, ТАЛБАЙН НЭР, ТАЛБАЙН
ХЭМЖЭЭ, СОЛБИЦОЛ, ХАЙГУУЛЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Талбай байрших сумын нэр	Талбайн нэр	Солбицол						Хугацаа	Талбайн хэмжээ
				Уртраг			Өргөрөг				
				град	мин	сек	град	мин	сек		
1	Хабун мандал	Жаргалан	Хужирт-1	95	40	2.22	46	53	40.83	3 жил	274.52
				95	37	59.75	46	53	40.83		
				95	37	59.75	46	53	5.32		
				95	39	41.5	46	53	5.32		
				95	39	41.5	46	53	12.58		
				95	40	2.22	46	53	12.58		

__ооо__